



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн
салбар зөвлөл байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 4.5, 5.6, 5.7 дахь заалт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.2, 2.4, 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэд дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Салбар зөвлөлийн
дарга:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
дарга Д.Дамдинцэрэн.

Гишүүд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд
дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга
Ш.Булган;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд
дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга
А.Намсаманд;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга
Х.Ариунболд;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Захиргааны удирдлагын газрын дарга
С.Батбямба;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Хяналт шалгалтын газрын дарга М.Алтан-Очир;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Хуулийн хэлтсийн дарга Ц.Очгэрэл;

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Хүний нөөцийн хэлтсийн дарга Э.Наранхүү

ТАЗ тогтоол 2019

19000541

Салбар зөвлөлийн
нарийн бичгийн дарга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
Захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Д.Энхтайван.

2.Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга /Д.Дамдинцэрэн/- д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишгийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 147 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2016 оны 87 дугаар тушаал, “Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн даргын 2016 оны 90 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

「 Салбар зөвлөлийн даргын үүрэгт ажлаас
чөлөөлж, томилох тухай


Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.6 дахь заалт, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 28 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Д.Дамдинцэрэнг чөлөөлж, тус газрын дарга Д.Загджавыг Салбар зөвлөлийн даргаар томилсугай.

2. Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, салбар зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга /Д.Загджав/-д үүрэг болгосугай.

3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

20000673



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн
гишүүнийг чөлөөлж, томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүнээс хурандаа Шархүүгийн Булган, Адыабазарын Намсаманд, Цэдэвсономын Очгэрэл нарыг чөлөөлсүгэй.

2.Тус Салбар зөвлөлийн гишүүнээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга, бригадын генерал Дамдинсүрэнгийн Дамдинцэрэн, дэд дарга, хурандаа Чойжамцын Оюунцэцэг, Захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Чимэддоржийн Нэргүй нарыг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс томилсугай.

3.Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4.Салбар зөвлөлийн гишүүдийг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн дарга, хурандаа (Д.Загджав)-д даалгасугай.

5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж буй байдалд нь хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ажлын алба /Ж.Эрдэнэбат/-нд даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг
чөлөөлж, томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Улсын Их хурлын 2019 оны 02 дугаар сарын 1-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 5.6 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаас хошууч Дагвасамбуугийн Энхтайванг чөлөөлсүгэй.

2.Тус Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч Б.Золзаяаг 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс томилсугай.

3.Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-д дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэх, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах ажлыг өдөр тутмын шуурхай зохион байгуулалтаар ханган, "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (хошууч Б.Золзаяа)-д үүрэг болгосугай.

4.Тус салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн дарга (хурандаа Д.Загджав)-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

22000636



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн гишүүнийг чөлөөлж,
томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.4, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүнээс Д.Дамдинцэрэнг чөлөөлж, Салбар зөвлөлийн гишүүнээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Б.Нандинболорыг 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс томилсугай.

2.Тус Салбар зөвлөлийн гишүүнийг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн дарга (хурандаа Д.Загджав)-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

22000855



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 644

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн даргыг чөлөөлж,
томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 5.6 дахь, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1.Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн даргаас бригадын генерал Дэлэгийн Загджавыг чөлөөлсүгэй.

2.Салбар зөвлөлийн даргаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Оюунхүүгийн Амарсанааг 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс томилсугай.

3.Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулж, "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга (хурандаа О.Амарсанаа)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолыг холбогдох алба тушаалтанд хүргэж, Салбар зөвлөлийн даргыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (Г.Билгүүн)-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн гишүүнийг
чөлөөлж, томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.4, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүнээс хурандаа Чимэддоржийн Нэргүй, хурандаа Машлайн Алтан-Очир, хурандаа Сайнбаярын Батбямба нарыг чөлөөлсүгэй.


2.Тус Салбар зөвлөлийн гишүүнээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, дэд хурандаа Батбаатарын Дашдаваа, Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын дарга, хурандаа Пэлжээгийн Батзориг, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа Бумдарийн Батбаяр нарыг 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс томилсугай.

3.Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулж, "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4.Салбар зөвлөлийн гишүүдийг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга (хурандаа О.Амарсанаа)-д зөвлөсүгэй.

5.Энэ тогтоолыг холбогдох албан тушаалтанд хүргэж, Салбар зөвлөлийг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (Г.Билгүүн)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БААТАРСАЙХАН

23330 80